

## ТАНИЛЦУУЛГА

Алтангэрэлийн Мөнх-Оргил /Хэл бичгийн ухааны доктор (Ph.D), дэд профессор/

Хэнтий аймгийн Батширээт суманд төрсөн. Монгол Улсын Их Сургуулийн Улаанбаатар Сургуульд Дорно дахин судлалын тэнхимийн эрхлэгчээр ажилладаг.

2006 онд *“Шилжилтийн үеийн яруу найргийн шинэ төлөв хандлага” (1980 хэдэн оны зарим яруу найрагчдын бүтээлийн жишээн дээр)* сэдвээр Хэлбичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2009 онд дэд профессор цол хүртсэн. 2014 онд “Алтан гадас” одон, 2021 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон тус тус хүртсэн. 2019 онд судалгааны бүтээлээр “Нацагдоржийн нэрэмжит шагнал” хүртсэн.

Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн судалгааны чиглэлээр ажилладаг. Уран зохиол судлалын чиглэлээр *“Шинэчлэгчдийн тухай тэмдэглэл”* (УБ. 2005), *“Шүүмжлэлт сэтгэлгээний эрэл”* (УБ. 2009), *“Шилжилтийн үеийн яруу найргийн шинэ төлөв хандлага”* (УБ. 2008), *“Монгол туужийн туурвилзүй”* (УБ. 2011), *“Монголын орчин үеийн урлаг, утга зохиолын шүүмж”* (УБ. 2014, Ш.Баттөрийн хамт), *“Хорлоогийн Самтилдэндэв: Эрдэм судлал”* (УБ. 2015, С.Байгалсайхан, Ш.Баттөр нарын хамт), *“XX зууны монголын уран зохиол”* (УБ. 2017, Ш.Баттөр, Э.Батжавхлан нарын хамт), *“Монголын шинэ үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн найруулал”* (УБ. 2018, С.Байгалсайхан, Д.Цэдэв, Ш.Баттөр нарын хамт), *“Шилжилтийн үеийн жүжгийн зохиолын туурвилзүй”* (УБ. 2020), *“Зохиолч, найруулагчийн урланд-1”* (УБ., 2022, Б.Мөнхдоржийн хамт) зэрэг ном бичиж хэвлүүлсэн.